

## ИЛТГЭХ ХУУДАС



“Стратеги төлөвлөгөө-2050”, “Хүний нөөцийн стратеги 2021-2030”, “Төмөр замын тээврийн хөгжлийн хөтөлбөр 2050” хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд 2024 оны эхний хагас жилийн байдлаар явцын хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай

2024 он

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн Төлөөлөн улирдах зөвлөлийн 2021 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 02 дугаар тогтоолоор батлагдсан. “Стратеги төлөвлөгөө-2050”, мөн өдрийн 03 дугаар тогтоолоор батлагдсан “Төмөр замын тээврийн хөгжлийн хөтөлбөр 2050”, “Стратеги төлөвлөгөө-2050”, “Төмөр замын тээврийн хөгжлийн хөтөлбөр 2050” “Хүний нөөцийн стратеги 2021-2030” бодлогын баримт бичиг, бодлогын баримт бичгийн хөтөлбөрийн 2024 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хийлээ. Үүнд:

1. “Стратеги төлөвлөгөө-2050” нь нийт 9 зорилтын хүрээнд 34 арга хэмжээ хэрэгжиж байгаагаас 100% хэрэгжсэн-13, 90% хэрэгжсэн-10, 70% хэрэгжсэн-10, 0% хэрэгжсэн-1 арга хэмжээ байна. Нийт хэрэгжилт 85,2 %-тай “Тодорхой үр дүнд хүрсэн” гэсэн үр дүнтэй байна.

Нийт арга хэмжээ	Үүнээс							Биелэлтийн хувь
	100%	90%	70%	50%	30%	0	Хугацаа болоогүй	
34	13	10	10	-	-	1	-	85,2%

**Дүгнэлт:** Хөтөлбөрийн явцын үнэлгээний дүгнэлт: Тус хөтөлбөр нь нийт 9 зорилтын хүрээнд 34 арга хэмжээ хэрэгжиж байгаагаас  
100% хэрэгжсэн-13  
90% хэрэгжсэн-10  
70% хэрэгжсэн-10  
0% хэрэгжсэн-1  
Нийт хэрэгжилт 85,2%-тай байна.

#### **Зөвлөмж:**

Цаашид хөтөлбөрийн Тэргүүлэх чиглэл-6 буюу Компанийн хүний нөөцийн хөгжил зорилтын хүрээнд хэрэгжиж байгаа арга хэмжээ болон Тэргүүлэх чиглэл-8 Санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр хэрэгжиж байгаа арга хэмжээний үр дүнг идэвхжүүлэн ажиллах.

**Жишээ нь:** Хүний нөөцийн бүрдүүлэлтийг чадварлаг, мэргэшсэн байдлаар сонгох, ажилчдын тогтвортой ажил эрхлэлтийг хангах талаар тодорхой арга хэмжээ авах.

Компанийн зарим чиг үүрэгт мэдээллийн технологид суурилсан ERP систем нэвтрүүлсэн байх арга хэмжээний хүрээнд тодорхой ажил хийгдээгүй байгаа тул илүү хэрэгцээ шаардлагатай байгаа системийг хэрэгжүүлэх талаар Санхүү, төлөвлөлтийн газар тодорхой арга хэмжээ авах.

2. “Хүний нөөцийн стратеги 2021-2030” бодлогын баримт бичгийн 2024 эхний хагас жилийн хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хийлээ. Тус хөтөлбөр нь нийт 5 зорилтын хүрээнд 30 арга хэмжээ хэрэгжиж байгаагаас 100% хэрэгжсэн-10, 90% хэрэгжсэн-7, 70% хэрэгжсэн-13 арга хэмжээ байна. Нийт хэрэгжилт 84,6 %-тай “Тодорхой үр дүнд хүрсэн” гэсэн үр дүнтэй байна.

Нийт арга хэмжээ	Үүнээс							Биелэлтийн хувь
	100%	90%	70%	50%	30%	0	Хугацаа болоогүй	
30	10	7	13	-	-	-	-	84,6%

**Дүгнэлт:** Хөтөлбөрийн явцын үнэлгээний дүгнэлт: Тус хөтөлбөр нь нийт 5 зорилтын хүрээнд 30 арга хэмжээ хэрэгжиж байгаагаас

100% хэрэгжсэн-10, 90% хэрэгжсэн-7, 70% хэрэгжсэн-13 нийт хэрэгжилт 84,6%- тай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэсэн үзүүлэлттэй байна.

**Зөвлөмж:** Цаашид Хөтөлбөрийн Тэргүүлэх чиглэл 2 буюу Байгууллагад ажилтнууд тасралтгүй суралцдаг системийг бий болгох, авьяас чадварын хөгжлийн ба карьерын менежментийг цогцоор нь хэрэгжүүлэх зорилтын биелэлт дунджаар 70 хувьтай хэрэгжиж байна.

2022 онд хийгдэж дуусахаар төлөвлөгдсөн арга хэмжээ бүрэн гүйцэд хийгдээгүй байгаа тул хөтөлбөрийн заалтыг он тус бүрээр төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх нь зүйтэй.

**3. “Төмөр замын тээврийн хөгжлийн хөтөлбөр 2050”-ийг хэрэгжүүлэх нэгдүгээр үе шат нийт 6 зорилтын хүрээнд 38 арга хэмжээнд үнэлгээ хийхэд 87,5 хувьтай байгаа бөгөөд “Зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүнд гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнд нэмэгдүүлэх шаардлагатай” гэсэн үнэлгээтэй байна.**

Үүнээс хугацаа болоогүй боловсруулах, шийдвэрлэх шатандаа байгаа 2, 50 хувьтай 4, 70 хувьтай 6, 90 хувьтай 7, 100 хувьтай 19 арга хэмжээ байна.

Нийт	Үүнээс					Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
	100%	90%	70%	50%			
38	19	7	6	4	2	87,5 %	

Цаашид хөтөлбөрийн 70, 50, 30 хувийн хэрэгжилттэй байгаа дараах арга хэмжээг эрчимжүүлэх нь зүйтэй.

### **ЗӨВЛӨМЖ:**

- Хөтөлбөрийн хэрэгжилтийг ирүүлэхдээ Тээврийн удирдлагын газар заасан хугацаанд Засгийн газрын 206 дугаар тогтоолд заасны дагуу 2000 тэмдэгтэд багтаан, товч бөгөөд тодорхой ирүүлж хэвших;
- Төсөл хөгжлийн газар, Тээврийн удирдлагын газрууд Гэрээнд заасан хугацаанд дуусаагүй байгаа төслүүдийн гүйцэтгэлийг ерөнхий гүйцэтгэгчээс шаардах; /Тухайлбал үйл ажиллагаа явуулах боломж бүрдсэн ч дээрх шалтгааны улмаас зүтгүүрүүд нийлүүлэгдээгүйгээс УБТЗ ХНН, Бодь интернэшнл ХХК-ийн зүтгүүрүүдээр тээвэрлэлт хийж, түрээсийн төлбөр төлж байна/.
- Захиргааны удирдлагын газар нь тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбоотой дутуу байгаа ажлыг байрыг бүрдүүлж, тээвэрлэлтийн үйл ажиллагааны тасралтгүй найдвартай аюулгүй ажиллагааг хангаж ажиллах

Хавсралт .....хуудастай.

ТАНИЛЦСАН:  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ХЯНАСАН:



Н.БУДБАЯР


ХШУДАА-НЫ ДАРГА  
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:  
ХШУДАА-НЫ АУДИТОР



Н. МӨНХСҮРЭН

Ц. НУГАРМАА

ХШУДАА-НЫ АУДИТОР



Л. УУГАНЦЭЦЭГ